



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/386

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.12 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 41 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж байгаа “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд Хөвсгөл аймгийн оролцох баг бүрэлдэхүүний тоглолт, үйл ажиллагааны зардалд 15.000.000 (арван таван сая) төгрөг зарцуулсугай.

2. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцох зардал 15.000.000 төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хангах” хөтөлбөрийн “Засаг даргад хуулиар олгосон эрх хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөрөнгийг зохих журмын дагуу төлөвлөсөн үйл ажиллагаанд зарцуулж тайлагнахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар), Соёл, урлагийн газрын дарга (Л.Батцэцэг) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011146

Захирамж2024